

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН 2021 ОНЫ 09 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр

Баруун-Урт сум

НЭГ.ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тус Тамгын газар 9 дүгээр сард:

- Явсан бичиг 38
- Ирсэн бичиг 25
 - Хариутай бичиг 10
 - Хугацаандаа явсан 7
 - Хугацаа болоогүй 3

Ирсэн бичгийг цаг тухай бүрт удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтэн, албан хаагчид хяналтын хуудас хөтлөн хүлээлгэж хариутай бичгүүдийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.

Өдөр тутмын үйл ажиллагаандаа архив, албан хэргийн хөтлөлтийн стандарт, журмыг мөрдөн ажилласан.

Тайлант сарын байдлаар Засаг даргын “А” захирамж- 13, Б захирамж-1, Тамгын газрын даргын “Б” тушаал-5, А тушаал-1 тус тус гарсан байна.

22 иргэнд архивын лавлагаа өгсөн байна.

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, тус Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, чадамжийг сайжруулахын тулд Чанарын удирдлагын тогтолцоо 9001 стандартыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд гол анхаарал хандуулан ажилласан. Стандартын 4 дүгээр үе шат болох Хэрээгжүүлэлт хэсгээр байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг тодорхойлж SWOT шинжилгээг байгууллага дээрээ хийж гүйцэтгээд байна. Төслийн багт 18 албан хаагч хамрагдаж байгаа бөгөөд 4 удаагийн цахим хичээл, 4 удаа цахим зөвөлгөө, 3 удаагийн даалгаврыг хийж гүйцэтгээд байна.

ХОЁР: БАЙГАЛЬ, ОРЧИН, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

2021 оны төлөвлөгөөний дагуу хийгдэх, дэд бүтэц, газар зохион байгуулалтын ажлууд хийгдэж байгаа бөгөөд Захирагчийн албаны зүгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- Нийт 9-н байршилд камержуулж хяналтын цэгт холбох ажлыг хийж гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт сумын 2-р багийн нутаг дэвсгэр Саруул хотхоны дунд камержуулах ажлын Талын технологи ХХКомпаниар хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.
- 1-р багийн нутаг дэвсгэр Мандал хорооллын хуучнаар механикжуулалтын байрны 19-н айл өрхийг газар чөлөөлтөд хамруулан гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын явц 60 хувь.
- Монгол улсын иргэн газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хүрээд Баруун-Урт сумын 9-р багийн зүүн талд 200 иргэнд газар өмчлүүлэх ажлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5,9-р багийн дунд баригдах зөөврийн усан сан барих, 4-р багийн жишиг хашаа барих ажлын тендерийг хууль тогтоомжийн дагуу зарлаад байна.
- Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт сумын 8-р багаар ажлын хэсэг явц зөвлөмж хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Золбин нохой устгах ажлын хүрээнд Сүхбаатар тохижил ОНӨААТҮГ хамтран 18 нохойг устгах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
- Багийн нутаг дэвсгэр дээрх их хэмжээний борооны ус тогтдог газруудад багийн Засаг нартай хамтран шороо асгаж тэгшүүлэх ажлыг 9-н байршилд хийж гүйцэтгэсэн.
- Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар сумын 6-н багийн нутаг дэвсгэрт 84 ширхэг цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлыг “Уртын гэгээ” ОНӨААТҮГ хийж гүйцэтгээд байна.
- Аймгийн төвийн хэсгүүдэд 200 ширхэг лед гэрэл байршуулах ажлыг “Уртын гэгээ” ОНӨААТҮГ Газар 80 хувьтай хийж гүйцэтгэж байна.
- 7-р багийн нутаг дэвсгэр 48-н айлын гадна нийтийн эзэмшлийн барилга байгууламжийн гадна дулаалга хөөсөн пассат хийх ажлыг Ёст бэйс ХХКомпани гүйцэтгэж байгаа ба хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэж байна.
- 7-р багийн нутаг дэвсгэр 27а, 27б, 36а, 36б байрны нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр засварлах ажлыг Хайлааст гарам ХХКомпани шалгаран хийж гүйцэтгэж байгаа ба ажлын явц 60 хувьтай гүйцэтгэж байна.

ГУРАВ: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

- ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ХАА-3 мэдээг 4-н аж ахуй нэгжээс, газар тариалангийн үнийн ХАА-10 мэдээг авч Статистикийн хэлтэст хүргүүлсэн.
- Сумын хэмжээнд 16 га талбайгаас 15.4 тн хүнсний ногоо хурааж аваад байна.
- 3 иргэнд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
- Устгалын комисс 1 удаа хуралдсан. Мэргэжлийн хяналтын газраас хураагдан ирсэн 50 кг байцааг хүлээн авч, устгалд оруулан холбогдох акт, бичиг баримтыг Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар хүргүүлсэн.
- Үхрийн арьс товруутах гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж 39 өрхийн 3023 үхэр, 1125 тугалд тус бүр үзлэг хийж вакцинжуулсан. 15 өрхийн хашаа, хороо, бэлчээрийн 20800 мкв талбайд ариутгал хийж, 40 үхрээс арьс товруутах өвчний 80 дээж авч Нийслэлийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.

ДӨРӨВ. ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Төрийн үйлчилгээний оператораас 62-н төрлийн үйлчилгээ лавлагааг иргэдэд түргэн шуурхай үйлчилсэн байна.

Үүнийг ангиллавал:

- Нийгмийн талаарх шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлт -19
- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-15
- Иргэний үнэмлэхний лавлагаа-11
- Үл хөдлөх хөрөнгийн жагсаалт-5
- Оршин суугаа хаягын лавлагаа-4
- Төрсний гэрчилгээ-4
- Жолоочийн лавлагаа-4
- Жолооны үнэмлэх захилга-2

- Шүүхийн шийдвэрийн бусдад өр төлбөргүй эсэх лавлагаа-2
- Үл хөдлөх хөрөнгийн жагсаалт-1

10-н иргэнд гар утасны апплейкшин ашиглан үйлчилгээ үзүүлсэн.

- Спорт заалны вакцинжуулалтын цэгүүдээр явуулын самбар байршуулан e-mongolia төрийн үйлчилгээнээс вакцинжуулалтын гэрчилгээг авах, зааварын дагуу иргэдэд гарын авлага тарааж, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.
- Орон нутгийн BBS телевизээр e-mongolia төрийн цахим үйлчилгээний талаар мэдээлэл шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан.
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үзэсгэлэн “ICT EXPO” энэ жилээс эхлэн цахим шилжилтэд түүчээлэх үндэсний арга хэмжээ болон өргөжиж, “Digital Nation-2021” нэр дор энэ сарын 17-19-ний хооронд Үндэсний соёл амралтын хүрээлэнд зохион байгуулагдах арга хэмжээний талаар цахим орчмоор мэдээлэл түгээсэн.
- Иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх, мэдээллээр хангах зорилгоор baruun-urt.su.gov.mn сайт, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар албан ёсны пейж хуудас, 9-н багийн групп хуудсаар ковид 19 өвчний цаг үеийн мэдээ мэдээлэл, Тамгын газраас хийж хэрэгжүүлж байгаа мэдээг нийтлэн хүргэж байна.

ТАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БАЙГАА АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ

- Баруун-Урт – Улаанбаатар чиглэлийн хөдөлгөөнд хяналт тавих, постын өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган ажиллаж байна.
- Коронавируст халдварт өвчний батлагдсан тохиолдлын тусгаарлан эмчлэх байранд ажиллаж байсан 27 эмчийг тусгаарлах /Амгалант дэнж, Урт цагаан, Соло/ байрны халдвар хамгааллын дэглэмийн дагуу бэлдэж, шаардлагатай бэлэн байдлыг байнга ханган ажиллаж байна.
- Тусгаарлан ажиглах байранд орсон иргэдийн хоол ор хоногийн төлбөрийг тооцоолон гаргаж холбогдох албан тушаалтад хүргүүлсэн .
- Аймгийн Онцгой комиссын баталсан хувиарын дагуу татан авалтад ажиллах тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах.
- Тээврийн хэрэгсэл болон тусгаарлах байрны коридор, өрөө бүрийг тухай бүр ӨЭМТөвөөр ариутгал хийлгэж нь тогтмол ариутган халдваргүйжүүлж Аймгийн МХГазрын холбогдох мэргэжилтэнгээр хянуулж ажиллаж байна
- Аюултай хог хаягдлыг Сүхбаатар Хот тохижилт ОНӨГазартай холбогдон тогтмол ачуулах зэрэг ажлыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.
- Вакцинжуулалтын нэмэлт 3- дахь тунгийн нэг цэгийг ажиллуулж мэдээг өдөр бүр гаргаж тайлагнаж байна Бруун-Урт сумын хэмжээнд 18-дээш насны иргэд 3-р тунд 30 % хамрагдаад байна. Хамрагдалтын хувь бага байгаатай холбогдуулан албан хаагчид вакцинд хамрагдах иргэдийн нэрсийг хувиарлан авч утасаар холбогдон хувийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

- Коронавируст халдварт өвчлөл эрс нэмэгдэж ӨЭМТөвүүдийн ажлын ачаалал нэмэгдсэнтэй хобоотой иргэдээс ирсэн санал гомдлыг холбогдох албан тушаалтад уламжлан улмаар Ковидын эсрэг үйлчилгээний нэг цэгийг ажилуулаад байна

ЗУРГАА: ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Төрийн сан нь төсвийн болон төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, төсвийн хэрэгжилтийг хангах, урсгал хяналтыг гүйцэтгэхэд анхаарал хандуулан ажиллаж байна. 9-р сарын байдлаар орон нутгийн болон төвлөрүүлэн захирагчийн харъяа байгууллагуудын 11 027 709.4 мянган төгрөгийн /5328/ мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулсан.

Төрийн сангийн хувьд 1 222 768.7 мянга төгрөгийн татварын болон татварын бус орлого орж, татварын орлого төлөвлөгөө 109 хувьтай байна.

Төрийн сан 18 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хянан хүлээн авч, нэгтгэн сумын гүйцэтгэлийн өр авлагын мэдээг программд оруулсан.

Төлбөр тооцооны өдөр тутмын ажил гүйлгээний баримтуудыг бүрэн бүрдүүлж, НББ-ийн журналтай тулгаж, тухай бүр төрийн сангийн харилцах, кассын мемориалын баримтуудыг үзэж архивын нэгж үүсгэсэн.

Орон нутаг хөгжүүлэх сангаар хийгдэж буй ажлын явц гүйцэтгэлийг onhs.mof.gov.mn сайтад тухай бүр мэдээллэж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, статистик мэдээ тайланд хяналт тавьж ажиллаж байна.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар